



2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ГАЗАРЗҮЙН УЛСЫН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Үндэслэл

Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 12 сарын 04-ний өдрийн А/420 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Улсын олимпиад зохион байгуулах журам", Газарзүйн олимпиадын хорооны 2025 оны 9 сарын 30-ны 14 тоот шийдвэрт үндэслэн энэхүү удирдамжийг боловсруулав. Ерөнхий боловсролын сургуулийн багш, дунд, ахлах ангийн суралцагчдын дунд газарзүйн олимпиад зохицуулахтай холбоотой харилцааг тус журмаар зохицуулна.

Нэг. Зорилго

Ерөнхий боловсролын сургуулийн газарзүйн хичээлийн сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах, сурагчдын бүтээлч сэтгэлгээ, чадварыг хөгжүүлж, Газарзүйн ухааныг сонирхон судлах сурагчдын тоог нэмэгдүүлэх, багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ. Тус олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн газарзүйн багш, суралцагчид хамрагдана.

Хоёр. Ерөнхий зохион байгуулалт.

Улсын газарзүйн олимпиад нь 3 даваатай байна. Даваа бүрийн зохион байгуулагдах хугацаа, ангилал дараах байдлаар зохицуулагдана.

Нэгийн даваа

- Нэгийн давааны (дунд, ахлах түвшний) асуулт даалгаврыг 2025 оны 11 сарын 11-нд аймаг, дүүрэг хариуцсан мэргэжилтэн, багш нараас авч, 11 сарын 12-нд сургуулийн олимпиадад оролцох хүсэлт гаргасан нийт сурагчдаар ажиллуулна.
- Хоёрын даваанд оролцох сурагчдын тоог сургуулийн сурагчдын тоотой харгалзуулж тооцно. 1000 хүртэлх сурагчтай сургууль ангилал тус бүрт 1 сурагч, 1000-2000 сурагчтай сургууль ангилал тус бүрт 2 сурагч, 2000-3000 сурагчтай сургууль ангилал тус бүрт 3 сурагч, 3000-аас дээш сурагчтай сургууль ангилал тус бүрт 4 сурагч гэж тооцно. 7, 8, 9 дүгээр ангийн сурагчид дунд ангийн төрөлд, 10, 11, 12 дугаар ангийн сурагчид ахлах ангийн төрөлд өрсөлдөнө.
- Сургууль бүр нэгийн даваанд оролцсон болон шалгарсан сурагчдын мэдээллийг 2025 оны 11 сарын 15-ны дотор аймаг, дүүрэг хариуцсан мэргэжилтэн, багш нарт илгээнэ. Хоцорсон сурагчдыг дараагийн шатанд хүлээн авах боломжгүй.

Хоёрын даваа

- Олимпиадын хоёрын даваа 2025 оны 12 сарын 16-нд 10:00 цагт аймгийн төвүүд, Улаанбаатар хотын дүүргүүдэд нэгэн зэрэг явагдана.

- Нэгийн даваанаас шалгарч, бүртгүүлсэн сурагчид хоёрын даваанд оролцно.
- Хоёрын даваа цахим хэлбэрээр, exam.net вэбсайтаар зохион байгуулагдана.
- Аймаг, нийслэлийн БШУГ-аас цахим олимпиадын үйл ажиллагааг мэргэжил, аргазүйн удирдлагаар ханган ажиллана.
- Олимпиадын хоёрын давааны асуулт даалгаврыг Газарзүйн Улсын олимпиад зохион байгуулах дэд хороо боловсруулж, цахим хэлбэрт оруулна.
- Хоёрын даваа хоёр шаттай байна. Нэгдүгээр шатанд цахимаар тест ажиллах ба нэгдүгээр шатнаас эхний 100 дотор шалгарсан багш сурагчид дараагийн шатанд оролцох эрхтэй болно. Хоёрдугаар шатанд цахимаар задгай даалгавар ажиллана. Засалтыг Улаанбаатар хотод нэгдсэн байдлаар хийж, эхний 50 байрт шалгарсан багш, сурагчдын дүнг 12 сарын 17-нд geography.mn вэбсайт дээр зарлана.
- 7, 8, 9 дүгээр ангийн сурагчид дунд ангийн төрөлд, 10, 11, 12 дугаар ангийн сурагчид ахлах ангийн төрөлд өрсөлдөнө.

Гурвын даваа

- Хоёрын даваанд эхний 50 байрт шалгарсан багш сурагчид гурвын даваанд оролцох эрх авна.
- Гурвын даваа 2026 оны 4 дугаар сарын 06, 07, 08, 09-нд зохион байгуулагдана.
- Гурвын давааны бүртгэлийг 2026 оны 04 дугаар сарын 06-ны өдөр 10-16 цагийн хооронд МУИС-ийн Газарзүйн тэнхим, 2 дугаар байрны 227 тоотод хийнэ.
- Бүртгүүлэхдээ БШУГ-ын батламж, иргэний үнэмлэх (төрсний гэрчилгээ), цээж зураг 2 хувь, томилолтын хуудсын хамт авч ирнэ.

Гурав. Үйл ажиллагаа

- Олимпиадын гурвын даваанд сурагчид эхний өдөр онолын даалгавар, хоёр дахь өдөр дадлага ажил, мультимедиа даалгавар гүйцэтгэнэ. Онолын даалгавар болон дадлага ажлын нэгдсэн дүнгээр сурагчдын олимпиадын эцсийн дүн тодорхойлогдоно.
- Багш нарын ангилал эхний өдөр явагдаж дүнгээ гаргана. Олимпиадын 2 дахь өдөр багш нарт зориулсан онол, аргазүйн сургалт хийнэ.
- Олимпиадын сүүлийн өдөр оноо хамгаалах хугацаа зарлаж, дүнг эцэслэнэ.

Дөрөв. Шагнал, урамшуулал

- 12-р ангийн ангилалд Аймгийн олимпиадад дэд байр, Нийслэлийн олимпиадад шагналт байранд шалгарсан сурагчид ЭЕШ-ын босго оноог хангасан нөхцөлд МУИС, МУБИС-ийн Газарзүйн мэргэжлийн хөтөлбөрт шалгалтгүй элсэн суралцах эрхийн бичиг олгоно.
- Газарзүйн хичээлийн Улсын олимпиадын гурвын даваанд багш нар тэргүүн байр 1, дэд байр 3, гутгаар байр 6, Сурагчдаас 9-р анги, 12-р анги тус бүр тэргүүн байр 3, дэд байр 6, гутгаар байр 9 шалгаруулж медаль, өргөмжлөл олгоно.

ГАЗАРЗҮЙН УЛСЫН ОЛИМПИАД
ЗОХИОН БАЙГУУЛАХ ДЭД ХОРОО

